



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/284

Эрдэнэт

┌ Цэргийн дүйцүүлэх албыг хаалгах, халах, ┐
сургалт явуулах, үүрэг гүйцэтгүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 /а/, 29.2 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны "Тооны дээд хязгаар, мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай" 51 дүгээр тогтоол, 2008 оны "Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам"-ын тухай 49 дүгээр тогтоолын 10 дугаар зүйлийн "Б" заалт, 14, 15 дугаар зүйл, 22 дугаар зүйлийн "З" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Цэргийн жинхэнэ албаны 2017 оны нэгдүгээр ээлжийн татлага "Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам"-ын дагуу 2017-2019 онуудад Цэргийн албыг биеэр дүйцүүлэн 2017 оны 05 дугаар сарын 15-наас алба хаалгах 20 иргэний нэрсийн жагсаалтыг нэгдүгээр, 2015-2017 онуудад Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хугацаа нь 2017 оны 05 дугаар сарын 20-нд дууссан халах 15 иргэний нэрсийн жагсаалтыг хоёрдугаар, 2016-2018 онуудад цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах 2, 2015-2017 онуудад цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хугацаандаа энэхүү журмыг зөрчсөн 2, 2016-2018 онуудад цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хугацаандаа энэхүү журмыг зөрчсөн 1 иргэнийг уг албанаас хасах нэрсийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

Хоёр. "Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам"-ын дагуу 2015-2017 онуудад орон нутагт цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа 12 алба хаагчдаар Баян-Өндөр сумын Булаг, Рашаант, Уртын гол багуудын нутаг дэвсгэрт үерийн усны суваг, ус өнгөрүүлэх хоолой, гүүрийг засварлах, шинээр хийх хойшлуулшгүй сэргээн босгох ажилд 2017 оны 05 дугаар сарын 15-20-ны хооронд 5 хоногийн хугацаатай үүрэг гүйцэтгүүлэхийг Цэргийн штабын дарга хурандаа Г.Батсуурьд даалгасугай.

Гурав. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах шийдвэр гарсан алба хаагчдтай цэргийн анхан шатны бэлтгэл сургалтыг Цэргийн штабын сургалтын танхим, Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын төвийг түшиглэн 2017 оны 05 дугаар сарын 29-нөөс 06 дугаар сарын 12-ныг дуустал 14 хоногийн хугацаатай зохион байгуулж явуулахыг Цэргийн штабын дарга хурандаа Г.Батсуурьд даалгасугай.

Дөрөв. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын ажил үүрэг гүйцэтгэх, сургалтанд шаардагдах төсвийг дөрөвдүгээр хавсралтаар баталж 5554000 /Таван сая таван зуун тавин дөрвөн мянган/ төгрөгийг орон нутгийн цэрэг татлага, дүйцүүлэх албаны цугларалт, бэлтгэл сургуулилтын зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ



D:(Zahiramj) A-4 doc
0200001326

Аймгийн Засаг даргын 2017 оны
05 дугаар сарын 23-ны өдрийн
4/28 дугаар захирамжийн дөрөвдүгээр
хавсралт

ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН ХААГЧДААР ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1.Ажлын багаж хэрэгслийн зардал					
1.	Ажлын бээлийн	хос	12	1000	12000
2	Ажлын хүрз	ширхэг	8	12000	96000
3	Жоотуу	ширхэг	2	15000	30000
Бүгд					138000
2.Хоол,цай ундааны зардал					
1.	Хоол /2017 оны 05 дүгээр сарын 15-20-ний өдрүүдэд/	12	5 хоног	5000	300000
Бүгд					300000
Тээврийн зардал					
1.	Маяти кран / Труба тээвэрлэх/	70	/Дизель түлш/литр	1750	122500
2.	Старикс / Цэргийн дүйцүүлэх алба хаагчдыг тээвэрлэх/	50	литр	1750	87500
Бүгд					211000
Нийт					649000

ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН ХААГЧДЫН СУРГАЛТАНД
ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1.Бичиг хэргийн зардал					
1.	Үзэг /бал/	20	ш	1000	20000
2.	Дэвтэр	20	ш	2000	40000
3.	Бичгийн цаас	0	0	0	0
4.	Самбарын үсэг	0	0	0	0
5.	Хавтас	0	0	0	0
6.	Хөтөлбөр	20	ш	0	0
7.	Хуудастай хавтас	2	ш	5000	10000
8.	Ном,гарын авлага	20	ш	0	0
Бүгд					70000
2.Хоол,цай ундааны зардал					
1.	Хоол	22	14 хоног	6000	1848000
Бүгд					1848000
3.Байрны зардал					
1.	Байр,буудал	22	0	0	0
Бүгд					0
4.Тээврийн зардал					
1.	Тээврийн зардал-Буудлага хийх /Говил ЗХ-ний 186 дугаар анги-полигон/	2	Машин /Зил-131/-1 Уаз-452-1	0	0

2.	Шатахуун	150 /А-80/	литр	1500	225000
Бүгд					225000
5.Хувцас, хэрэглэл					
1.	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах алба хаагчдын зуны китель, өмд	20	хос	102000	2040000
2.	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах алба хаагчдын зуны малгай	20	ширхэг	15000	300000
3.	БХЯ-наас зохион байгуулах Цэрэг-стратегийн цугларалтанд оролцох аймгийн удирдлагын хувцас /Зуны малгай, китель өмд, хавар намрын хүрэм,гутал/	китель,өмд-1 малгай-1 хүрэм-1 гутал-1	хос ширхэг ширхэг хос	115000 18000 139000 150000	422000
Бүгд					2762000
Нийт					4905000

00